

Комплаенсийн үйл ажиллагааны тайлан - 2025



2024 оны хоёрдугаар хагас жил

Агуулга

- Компаенсийн үүрэг
- ISO стандарт
- Компаенсийн эрсдэл
- Компаенсийн байнгын сайжруулалт
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Компани 2024 оны сүүлийн хагас жилд компаенсийн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж хууль, журмын нийцлийг хангуулах, компаенсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, компаенсийн соёлыг бэхжүүлэх, ач холбогдлыг таниулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, дотоод журмын шаардлагыг ханган ажиллаа.

Компаенсийн үүрэг

Заавал дагаж мөрдөх үүрэг: Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд хамраалтай хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу төрийн эрх бүхий зохицуулагч байгууллагуудад 19 төрлийн тайлан мэдээг давтагдсан тоогоор 71 удаа хүргүүлж, компаенсийн үүргийн нийцлийг хангалаа.

Дагаж мөрдөх үүрэг: Компанийн дотоод дагаж мөрдөх үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, удирдлагын хороодод тайлагнан, компаенсийн эрсдэл үүсч болзошгүй тохиолдлуудад санал, зөвлөмж бэлтгэн хүргүүлж ажиллаа.

- *Олон Улсын зах зээлд гаргасан Хулан бонд:* Хулан бондын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлж, тайлан болон бусад мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүллээ.
- *Ипотекийн зээлээр баталгаажсан бонд:* Тайлант хугацаанд тус бондын төлбөрүүдийг цаг хугацаанд нь төлж, хэлцэл эрхлэн гүйцэтгэгч, хөрөнгө

итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн холбогдох тайлан мэдээг зохих хугацаанд хүргүүллээ.

ISO стандарт

Дараах Олон улсын стандартуудын шаардлагыг хангаж, үйл ажиллагаандаа нийцүүлэн хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан байнгын сайжруулалтыг тасралтгүй хэрэгжүүллээ.

- ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдал;
- ISO 31000:2015 Эрсдэлийн удирдлага;
- ISO 37301:2021 Компаенсийн удирдлага.

Компаенсийн эрсдэл

Тайлант хугацаанд компаенсийн эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй, ёс зүйн зөрчилийн тохиолдол гараагүй. Мөн харилцагч нараас аливаа санхүүгийн, үйл ажиллагааны болон нэр хүндийн эрсдэл үүсэхүйц гомдол санал гараагүй.

Компаенсийн байнгын сайжруулалт

Сургалт, хөгжил: Тайлант хугацаанд шинэ ажилтнуудад улирал бүр, нийт ажилтнуудад цахим цуврал сургалт, мэдээллийг сар бүр тогтмол хүргүүлж компаенсийн соёлыг төлөвшүүлж, компаенсийн эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ажилласан. Мөн “Олон улсын комплайнсын стандарт” танилцуулах арга хэмжээнд “ISO37301 стандартыг нэвтрүүлсэн туршлага, үр дүн” сэдвээр өөрийн компанид нэвтрүүлсэн туршлага, үе шатууд, ач холбогдлын тухай илтгэл тавьж танилцууллаа.

Тайлагнал: Компаенсийн үүргийн хэрэгжилтийн хяналтыг сар бүр хэрэгжүүлж Удирдлагын хороонд тайлагнадаг. Мөн түүнчлэн компаенсийн

чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой санал зөвлөмжийг агуулсан комплаенсийн үйл ажиллагааны тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд бэлтгэн танилцууллаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Монгол улсын Мөнгө Угаах Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх тухай хууль болон

олон улсын гэрээ, хориг арга хэмжээнүүдийн шаардлагын дагуу компанийн харилцагч банк санхүүгийн байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудад харилцагчийг таньж мэдэх шинжилгээг хийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, тогтмол хяналт тавьж ажиллаа.

Хянан нийцүүлэлтийн газар

